

## “МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 08-ны өдөр

№ 30/02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Монос хүнс” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 28 тоот тогтоол, 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 30% (гучин хувь)-иар буюу 981,241,027.2 (Есөн зуун наян нэгэн сая хоёр зуун дөчин нэгэн мянга хорин долоон төгрөг хорин мөнгө) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 2.4 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохыг Гүйцэтгэх захирал (А.Отгондарь), Ерөнхий нягтлан бодогч (Ц.Дэлгэрмаа) нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, ногдол ашиг тараах мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Н.Цагаанхүү)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД